## “ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

# Дотоод хяналт, шалгалтын хэлтсийн 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлан

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| Стратеги төлөвлөгөөний зорилго **Нэг. Бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх** | | | | | | | | |
| 1 | ***Арга хэмжээ 1.1*** Байгууллагын үйл ажиллагааны эхний хагас жил, жилийн эцсийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Өөрийн хөрөнгө | Биелэлт хувь | 86,5% | 50% | 100% | Байгууллагын 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 217 дугаар тогтоол, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалыг үндэслэн нийт 14 чиглэлийн хүрээнд 82 ажлыг төлөвлөн ажилласан. 45 ажил нь “Үр дүнтэй” буюу 100 хувийн үнэлгээтэй, 21 ажил нь “Тодорхой үр дүнд хүрсэн” буюу 70-99 хувийн үнэлгээтэй, 15 ажил нь “Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 30-69 хувийн үнэлгээтэй, 1 ажил нь “Үр дүнгүй” буюу 0-29 хувийн үнэлгээтэй, нэгдсэн дүнгээр 87,6 хувийн үнэлгээгээр “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсэн. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээг гүйцэтгэх гэрээний дагуу үйлчилгээний гомдол, зам тээврийн осол зөрчил, техникийн саатал, ашиглалтын саатлыг бууруулж ажиллах ажлын хэрэгжилт хангалтгүй байгаа нь 2009, 2015 онд үйлдвэрлэгдэж шугамын үйлчилгээнд ажилласан их багтаамжийн болон дунд оврын автобусны насжилт дуусч, сэлбэг материалын олдоц ховордсон. Нийтийн тээврийн мэргэшсэн туршлагатай жолооч нарын дутагдалд орсон зэрэг шалтгаалсан гэж дүгнэсэн. | 100% |
| Хэсгийн дундаж үнэлгээ 100% | | | | | | | | |
| Стратеги төлөвлөгөөний зорилго **Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх** | | | | | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | ***Арга хэмжээ 2.1*** Байгууллагын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байгаа хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн зүйл заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Өөрийн хөрөнгө | Биелэлт хувь | 92,5% | 50% | 100% | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг дүгнэхдээ хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3-т заасан аргачлалыг баримтлан тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 2022 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн дүгнэж, үнэлгээ хийсэн. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хүрээнд Монгол улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Нийслэлийн Засаг Даргын захирамж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгавраас өгсөн нийт 36 шийдвэрийн 44 заалт тус үйлдвэрийн газарт “Бүрэн хэрэгжсэн” буюу 99,5 хувийн биелэлттэй гэж дүгнэн НЗДТГ-т хүргүүлсэн. | 99,5% |
| 3 | ***Арга хэмжээ 2.2*** Газрын даргын тушаалаар батлагдсан журам, дүрмийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Өөрийн хөрөнгө | Биелэлт хувь | 100% | 50% | 100% | Газрын даргын үйл ажиллагааны чиглэлээр гаргасан тушаалын хэрэгжилт, үр дүн, явц 69%-тай буюу “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж дүгнэсэн. Тушаалын хэрэгжилтийг хэлтэс тус бүрээр нь задалж, харуулбал:<br>❖ Газрын даргын үйл ажиллагааны чиглэлээр гаргасан 2018-2021 оны А тушаалын хэрэгжилтэд зөвлөн туслах хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлж байгаа 42 тушаалыг өөрчлөх шаардлагатай, бүтэц орон тоо өөрчилсөнтэй холбогдуулан ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулаагүй зэрэг зөрчлүүдийг арилгах шаардлагатай. Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэст зөрчлийн хуудас, зөвлөмж хүргүүлсэн. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | ***Арга хэмжээ 2.2*** Газрын даргын тушаалаар батлагдсан журам, дүрмийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Өөрий хөрөнг | Биелэлт хувь | 100% | 50% | 100% | ❖ Үйл ажиллагаанд хэрэгжүүлж байгаа хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа тушаалын жагсаалтыг хэлтэс тус бүрээр гаргаж, хэрэгжилтийн тайлан ирүүлэх талаар албан бичиг хүргүүлсэн. СБХ, ТТХ, ТҮХ-үүд заасан хугацаанд хэрэгжилтийн тайлан ирүүлсэн. Санхүү, бүртгэлийн хэлтэс 15 тушаал хэрэгжүүлж ажиллахаас 2018 оны А/49, 2021оны А/50 дугаар тушаалыг өөрчлөх тайлбар ирүүлсэн. Бусад 13 тушаалыг 100% хэрэгжүүлж ажилласан. Техник, технологийн хэлтэс 12 тушаал хэрэгжүүлж ажиллахаас А/19 дүгээр тушаалд тодотгол хийхээр хүлээгдэж байгаа. А/16 тушаалыг баримтлаж ажиллаагүй шалтгаан нь тээврийн хэрэгсэлийн насжилт дууссантай холбогдуулан хөргөлтийн шингэний шланк, батруба цоорох нь их байгаа тул жолоочид хамааралгүй хөргөлтийн шингэн олгосон.Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтэс газрын даргын А/25, А/42 дугаар тушаалыг 100% мөрдөж ажилласан. Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэс нийт 15 тушаал хэрэгжүүлэхээс 13 тушаалыг 97,3%-тай хэрэгжүүлж, газрын даргын 2020 оны А/39,43 дугаар тушаалыг хэрэгжүүлээгүй.Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн асуудал эрхэлсэн ажилтан Ц.Батчулуун заасан хугацаад хэрэгжилтийн тайлан ирүүлээгүй. Газрын даргын тушаалын хэрэгжил -тийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэлтсийн дарга нар болон мэргэжилтэнгүүд өөрийн хэлтэс, ажил албан үүрэгтэй холбоотой тушаалаа мэддэггүйгээс хэрэгжүүлээгүй. Ажлын хэсэг, комиссын бүрэлдэхүүнтэй хэрэгжүүлж ажиллах тушаалыг орхигдуулдаг зэрэг зөрчилтэй. ЗУХНХ-т тушаалын хэрэгжилтийг хэлтэс, албан тушаалтнаас хэрэгжүүлсэн эсэхэд тавих хяналтыг сайжруулж ажиллах талаар зөвлөмж хүргүүлсэн. Зөрчлийг арилгасан тайлан ирүүлээгүй. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | ***Арга хэмжээ 2.3*** Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Өөрийн хөрөнгө | Биелэлт хувь | 100% | 50% | 100% | Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтсээс үйлдвэрийн газрын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын хэрэгжилтийн тайлан ирүүлээгүй хяналт-шалгалт, үнэлгээ хийх боломжгүй. Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан үйлдвэрийн газрын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчилж, түүнтэй уялдуулан хөдөлмөрийн гэрээ, нууц хадгалах албан тушаалын жагсаалтыг дагуу 310 ажилтантай гэрээ байгуулсан. Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг заалт бүрээр нь хэрэгжүүлж, хагас, бүтэн жилээр тайлагнаж, Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтийг дүгнэх ажлыг эрчимжүүлэх талаар хүний нөөцийн ахлах ажилтан, хуулийн зөвлөх, архивч, хүний нөөцийн ажилтан нарт зөвлөгөө өгсөн. | 100% |
| 4 | ***Арга хэмжээ 2.4*** Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт, шалгалт хийх. | Өөрийн хөрөнгө | Биелэлт хувь | 100% | 50% | 100% | 2022 оны 10 дугаар сард удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн 24 үүрэг даалгавар явц 75,4%-тай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсэн.<br>Техник, технологийн хэлтэст 8 үүрэг даалгавар 75%, Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтэс 9 үүрэг даалгавар 75,5%, Санхүү, бүртгэлийн хэлтэс 2 үүрэг даалгавар 75%, Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэс 2 үүрэг даалгавар 75%, Дотоод хяналт, шалгалтын хэлтэс 3 үүрэг даалгавар 76,6%-тай.<br>Үүрэг даалгаврын биелэлтэд дүгнэлт хийхэд гүйцэтгэл биелэлт чанар муутай, хийсэн ажлаа тоон үзүүлэлт гарсан үр дүнг тооцон гаргадаггүй. Үг үсэг, утга найрууллага тааруу, албаны үг хэллэгт оруулж бичдэггүй, хэрэгжээгүй байгаа үүрэг даалгаврыг 100%-тай дүгнэсэн, сараар нэгтгэж гаргаагүй зэрэг зөрчилтэй.<br><br>Газрын даргад болон даргын зөвлөлийн хуралд үүрэг даалгаврын биелэлтэд хийсэн хяналт, шалгалтын тайланг танилцуулсан. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | **Арга хэмжээ 2.5.** Ажилдын ажлын файл, компьютерын мэдээллийн аюулгүй байдалд хяналт, шалгалт хийх | Өөрийн хөрөнгө | Биелэлт хувь | 100% | 50% | 100% | Үйлдвэрийн газрын захиргаа, инженер техникийн ажилчдын ажлын файлын эмх цэгц, компьютер, ERP системийн мэдээллийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор Дотоод хяналт, шалгалтын хэлтсийн ахлах ажилтан Л.Тулга, Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтсийн мэдээлэл технологийн ажилтан Б.Ганболд нар 2022 оны 11 дүгээр сарын 23, 25-ны өдрүүдэд хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, ажилчдад зөвлөгөө өгч ажилласан. Компьютерын код хүчингүй-23, ERP-ийн код хүчингүй-21, ажлын файл эмх цэгцгүй-25, Компьютерын мэдээллийн аюулгүй байдал хангалтгүй. Ажлын тайланг ДХШХ-ийн дарга Л.Отгонбаатараар хянуулан, газрын дарга О.Ганбаатарт танилцуулсан. | 100% |
| Хэсгийн дундаж хувь 99,8% | | | | | | | | |
| Стратеги төлөвлөгөөний зорилго **Гурав.”Байгууллагын үйл ажиллагааны үр дүн”** | | | | | | | | |
| 6 | ***Арга хэмжээ 3.1*** Захиргаа, удирдлага, хүний нөөцийн хэлтсийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Өөрийн хөрөнгө | Биелэлт хувь | 100% | 100% | 100% | Газрын даргын баталсан 2022 оны 06 дугаар удирдамжийн дагуу Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтсийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулсан. 14 арга хэмжээгээр дүгнэж үзэхэд 59,9% буюу ажлыг “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж дүгнэсэн. Газрын даргад хийсэн ажлын тайланг танилцуулж, Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэст зөвлөмж хүргүүлсэн. (Зөвлөмжийн дагуу хийсэн ажлын тайланг 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр Дотоод хяналт, шалгалтын хэлтэст ирүүлэх) | 90% |
| 7 | ***Арга хэмжээ 3.2*** Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх | Өөрийн хөрөнгө | Биелэлт хувь | 100% | 100% | 100% | Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтсээс “Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр” гаргаагүй хяналт-шалгалт, үнэлгээ хийх боломжгүй. Өндөр насны тэтгэвэрт гарсан 3 ажилтанд нийт 38,403,0 мян.төгрөгийн тэтгэмж олгосон. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | ***Арга хэмжээ 3.2*** Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх | Өөрийн хөрөнгө | Биелэлт хувь | 100% | 100% | 100% | Гэрлэх ёслолын ордонд ажилтнуудыг хуримлуулах хамтран ажиллах гэрээ байгуулан тайлант хугацаанд 5 ажилтны ёслолын үйл ажиллагааг зохион байгуулсан. Байгууллагад удаан жил ажилласан 1 ажилтанд 206,381,0 мян.төгрөгийн нэмэгдэл 1 удаа олгосон. Мэргэшсэн инженерийн зэрэгтэй 2 ажилтанд зэргийн нэмэгдэл олгосон. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг 60%-тай буюу ажлыг “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж дүгнэсэн. “Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг боловсруулан батлуулж мөрдөж ажиллах, ажилчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулах талаар зөвлөмжийг ЗУХНХ-т хүргүүлсэн. | 100% |
| 8 | ***Арга хэмжээ 3.3*** Түлш, тос, тослох материалын зарцуулалтад хяналт, шалгалт хийх | Өөрийн хөрөнгө | Биелэлт хувь | 100% | 100% | 100% | Түлш, тос маслын зарцуулалтын тайланд үнэлгээ хийгээд Санхүү, бүртгэлийн хэлтсээс бүртгэлээр тавих хяналт хангалтгүй, зарцуулалт өндөртэй тэргийг засварлуулах талаар Техник, технологийн хэлтэс, Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтэстэй хамтран ажил зохион байгуулаагүй.<br>Сар бүрийн түлш хэмжих ажил үр дүнгүй, хэтрэлт хэмнэлтийн тооцоог мэдээллэхээс өөр зохион байгуулсан ажил байхгүй.<br>Актлагдсан болон актлагдах нийт 21 тэрэгнээс 6 тэрэгний банкинд байгаа 367,48.00 (гурван зуун жаран долоон мянга дөчин найман) литр түлшийг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар султгаж аваагүй. Үнэлгээ 65%-тай буюу ажлыг “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж дүгнэсэн.<br>Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтанд тулгуурлан хийсэн хяналт, шалгалтын ажлын тайланг газрын даргад танилцуулж, Санхүү, бүртгэлийн хэлтэст ажил сайжруулах зөвлөмж хүргүүлсэн. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Зөвлөмжийн дагуу хийсэн ажлын тайлан ирүүлсэн. Актлагдсан тэрэгнүүдийн банкинд байгаа түлшийг султгасан. | |
| 9 | ***Арга хэмжээ 3.4*** Сэлбэгийн материалын зарцуулалтын тооцоонд хийх хяналт, шалгалт | Өөрийн хөрөнгө | Биелэлт хувь | 100% | 100% | 100% | Газрын даргын 05 дугаар удирдамжийн дагуу сэлбэгийн тооллогыг 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс 10 дугаар сарын 28-ны өдрийн хооронд зохион байгуулсан. Тооллогоор каунти маркын автобусны 61 төрлийн 424 ширхэг сэлбэг тоолохоос 405 ширхэг сэлбэг тоолсон. 19 ширхэг сэлбэг шаардах хуудсаар зарлагадсан. Эко автобусны 50 нэр төрлийн 557 ширхэг сэлбэг тоолохоос 556 ширхэг сэлбэг тоолж, 1 ширхэг цахилгаан хэлхээний удирдлагын блок шаардах хуудас зарлагдаж техникийн түргэн тусламжийн 28-03УБС дугаартай машинд тавьсан. Шалгалтаар илэрсэн зөрчил:<br>Гараж 3-043 дугаартай автобус дээр 2022 оны 10 дугаар сарын 16-ны өдөр статер 1 ширхэг, форсунк 2 ширхэг шаардах хуудсаар зарлагдсан Засварын ажлын гүйцэтгэлийн бүртгэлийн дэвтрийг шалгахад 485,000.00 (дөрвөн зуун наян таван мянган) төгрөгийн өртөг бүхий статер 1 ширхэг, 1,060,800.00 (нэг сая жаран мянга найман зуун) төгрөгийн өртөг бүхий форсунк 2 ширхэгийг сольсон талаар тэмдэглэл байгаагүй. Эко маркын автобусны сэлбэгийг тоолох явцад 10010002812 барааны кодтой 1 ширхэг нь 745,437.00 (долоон зуун дөчин таван мянга дөрвөн зуун гучин долоон) төгрөгийн нийт 10 ширхэг 7,454,370.00 (долоон сая дөрвөн зуун тавин дөрвөн мянга гурван зуун далан )төгрөгийн өртөг бүхий үнэтэй кардан гол гэж гар карданы удирдлага тоолуулсан зэрэг зөрчил илэрсэн. Эндээс харахад шаардахаар гарсан сэлбэг материалыг тухайн завсарт орж байгаа тэргэнд тавьсан эсэхэд тавих хяналт тааруу. | 100% |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Сэлбэгийн няравууд хуучин сэлбэгийг хурааж авдаггүй. Сэлбэг нийлүүлэгч компаниас ирсэн сэлбэгийг зарлагын падаантай тулгалт хийхдээ алдаа гаргасан зэрэг зөрчилтэй. Хийсэн ажлын тайланг газрын даргад танилцуулан СБХ-т зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжийн дагуу ирүүлсэн шаардлага хангахгүй тул буцаасан. | |
| 10 | ***Арга хэмжээ 3.5***<br>Санхүү, бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Өөрийн хөрөнгө | Биелэлт хувь | 0% | 100% | 100% | Газрын даргын баталсан 2022 оны 02 удирдамжийн 2022 оны 03 сарын 01-ний өдрөөс эхлэн 04 сарын 22–ны өдрийн хооронд Санхүү, бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж ажилласан. Үйл ажиллагааны явцыг 80%-тай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсэн.<br>Шалгалтаар дараах зөрчлүүд илэрсэн.<br>❖ Авлага барагдуулалт хангалтгүй.<br>❖ Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 29 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.<br>❖ Сэлбэггүй удаан хугацаагаар зогссон автобуснуудад шаардахаар сэлбэг олгосон.<br>❖ 2021 онд шинээр ажилд орсон жолооч эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуул-лаагүй.<br>❖ Үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлө - гөөнд хэрэгжүүлэх арга хэмжээний 3.1, 3.4 дэх ажил давхацсан.<br>❖ Санхүү, бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааны жилийн эцсийн гүйцэтгэлийн баталгаажсан төлөвлөгөөний биелэлтийг шалгалтын явцад өгөөгүй, эдийн засагч Ө.Ганзоригоос файлаар өгсөн төлөвлөгөөний биелэлт гаргасан төлөвлөгөөний дагуу гаргаагүй, зөрүүтэй тайлагнасан. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 7 дугаар хавсралтын дагуу боловсруулж гаргаагүй. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | ***Арга хэмжээ 3.5***<br>Санхүү, бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Өөрийн хөрөнгө | Биелэлт хувь | 0% | 100% | | ❖ Зарим хэрэгжүүлээгүй арга хэмжээний заалтыг тайланд хэрэгжээгүй шалтгааныг бичихгүйгээр шууд хасч тайлагнасан.<br>Төлөвлөгөөний биелэлт гаргахдаа тоон үзүүлэлт, өссөн дүн, өмнөх оны үзүүлэлттэй харьцуулалт хийдэггүй.<br>❖ Хэлтсийн ажилчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө-Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 6 дугаар хавсралтын дагуу боловсруулаагүй, ажлын байрны тодорхойлолт болон хэлтсийн төлөвлөгөөтэй уялдуулаагүй.<br>❖ Хэлтсийн ажилчдын гүйцэтгэлийн тайлан- Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 8 дугаар хавсралтын дагуу тайлан гаргадаггүй зэрэг нийтлэг зөрчилтэй.<br>❖ Хэлтсийн дарга ажилдын тайланг баталсан, ажлын гүйцэтгэл тооцоогүй тайланг хүлээн авч баталгаажуулсан зөрчилтэй.<br>❖ Шатахууны олголт, зарцуулалтын тооцоог тулган шалгахад сар бүр хэтрэлт, хэмнэлтийг тооцон гаргасан боловч үр дүнг тооцож ажилладаггүй.<br>❖ Түлшний хэтрэлттэй байгаа тэрэгний учир шалтгааныг тогтоолгох талаар Техник, технологийн хэлтэс, Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтэстэй хамтарч ажилладаггүй.<br>❖ Актлагдсан болон актлагдах нийт 21 тэрэгнээс 6 тэрэгний банкинд байгаа 367,48.00 (гурван зуун жаран долоон мянга дөчин найман ) литр түлшийг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар султгаж аваагүй.<br>❖ Газрын даргын 2019 оны А/17 тушаалын сэлбэг материалын хариуцлага тооцох журмын 2.3-т заасны дагуу төлбөр тавих анхан шатны баримт дутуу.<br>❖ Бараа материалын орлогын баримт дээр хянасан нягтлан бодогчийн гарын үсэг, гарын үсгийн тайлал дутуу | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ❖ Шаардах хуудасны сэлбэг хүлээн авсан хэсгийн гарын үсэг зөрүүтэй.<br>❖ Бараа материалын зарлагын баримт дээр хүлээлгэн өгсөн нярвын гарын үсэг дутуу.<br>❖ Сэлбэгийн нярвуудын гарын үсэг, гарын үсгийн тайлал зөрүүтэй.<br>❖ Шаардах хуудсыг эх хувиар нь биш хуулбарласан хувиар нь тайланд хавсаргасан.Зарлагын баримт дээр сэлбэг материалыг хүлээн авсан жолоочийн гарын үсгийг зуруулж баталгаажуулдаггүй.<br>❖ Шаардлага хангахгүй техникийн комиссын акт баримт болгон хавсаргасан.<br>❖ Зарлагын баримт, шаардах хуудас хамт хавсаргадаггүй зэрэг зөрчил илэрсэн. Хийсэн ажлын тайланг газрын даргад танилцуулж, СБХ-зөвлөмж, зөрчлийн хуудасны хамт хүргүүлсэн. СБХ-ээс зөвлөмжийн дагуу хийсэн ажлын тайлан ирүүлсэн. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | ***Арга хэмжээ 3.6*** Нийтийн тээврийн үйлчилгээний газартай байгуулсан гэрээний үүргийн биелэлтэд бүртгэлээр хяналт, шалгалтыг зохион байгуулах | Өөрийн хөрөнгө | Гэрээний биелэлт хувь | 100% | 100% | 100% | Нийслэлийн нийтийн тээврийн газартай байгуулсан гэрээний үүргийн биелэлтэд 2022 оны 11 сарын байдлаар 92.7 хувиар биелсэн.<br>Цагийн гүйцэтгэлийн хувьд дараах зөрчил илэрсэн.Үүнд:<br>❖ 2022 оны 11 сарын байдлаар 306114:20:00 (гурван зуун зургаан мянга нэг зуун арван дөрвөн цаг, хорин минут) даалгаварт цаг гүйцэтгэхээс 270048:57:00 (хоёр зуун далан мянга дөчин найман цаг, тавин долоон минут)цаг буюу 89,3%-ийн гүйцэтгэж, зорилтод түвшинг 0,7%-иар тасалсан. Ашиглалтын саатлын 5551:21:30 (таван мянга таван зуун тавин нэгэн цаг, хорин нэгэн минут, гучин секунт)цаг гарсан. Жолоочийн зөрчлөөс шалтгаалж 1155:47:00(нэг мянга нэг зуун тавин таван цаг, дөчин долоон минут) цагийг хасуулж, 51,988,170.00(тавин нэгэн мянга есөн зуун наян найм мянга нэг зуун далан)төгрөгийн торгуулийг Нийтийн тээврийн газраас ногдуулсан. Хяналт шалгалтын ажлын үр дүнд нийт алдагдсан цаг багасч эхний хагас жилээс цагийн түвшин 2,5 хувиар өссөн. Техникийн саатал 2021 оны 11 сарын байдлаар 10576:40 цаг, 2022 оны 11 сарын байдлаар техникийн саатал 13689:31:30 цаг гарч 3114:10:00 цагаар өссөн. Ашиглалтын саатал 2021 оны 11 сарын байдлаар 1942:50 цаг, 2022 оны 11 сарын байдлаар 5551:21:30 цаг гарч 3609:29:30 цагаар өссөн. Техник, ашиглалтын сааталтай цагууд өссөн нь техникийн бэлэн бус байдал, дугуй ихээр хагарч шугам замд зогсох, жолоочийн хүрэлцээ, нөөц дутмаг зэргээс шалтгаалсан. | 100% |
| | | | | | | | ❖ Тайлант хугацаанд газрын даргын баталсан нийтийн тээврийн үйлчилгээний MNS5012:2011 стандартын шаардлагын хэрэгжилтэд хяналт, шалгалтын ажлыг 9 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 780 зөрчил илэрсэн. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | ***Арга хэмжээ 3.7*** Нийтийн тээврийн үйлчилгээний MNS5012:2011стандартын шаардлагын хэрэгжилтэд хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулах | Өөрийн хөрөнгө | Стандарт шаардлага хангагдсан байна. | 100% | 100% | 100% | ❖ Илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар Тээвэрлэлт, үйчилгээний хэлтэс, Техник, технологийн хэлтэст зөвлөмж хүргүүлж ажилласан.<br>❖ Зөвлөмжийн дагуу зохион байгуулсан ажлын тайланг хэлтсүүдээс ирүүлсэн. Илэрсэн 780 зөрчлөөс 773 буюу 99,2%-тай зөрчлийг арилгаж, үр дүнг тооцон ажилласан.<br>❖ Газрын даргын 2022 оны А/55 дугаар тушаалын дагуу хэлтсийн ажилчид хариуцсан тэрэгний үзлэг шалгалтыг 6 удаа зохион байгуулж, үзлэг шалгалтын хуудсаар илэрсэн зөрчлийн тоо, хийсэн ажлын тайланг Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтсийн дарга П.Алтантөгсөд хугацаанд нь хүргүүлж ажилласан. Үзлэг шалгалтыг хийсэн ажлын үр дүнг тооцож ажилчдад урамшуулалт цалинг олгосон. Зөвлөмжийн дагуу арга хэмжээ зохион байгуулж, нийт илэрсэн зөрчлийг 99,2%-тай арилгаж, нийтийн тээврийн үйлчилгээнд стандартын шаардлага хангасан автобусаар үйлчилсэн. | 100% |
| 13 | ***Арга хэмжээ 3.8*** Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтсийн үйл ажиллагаанд газрын даргын баталсан удирдамжийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Өөрийн хөрөнг | Биелэлт хувь | 100% | 100% | 100% | ❖ Эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хийсэн. 14 арга хэмжээнд хяналт, үнэлгээ-шинжилгээг хийж хэлтсийн ажлын явц 59,5%-тай ажлыг “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж дүгнэсэн.<br>❖ НТГ-тай байгуулсан гэрээний үүргийн биелэлт- Эхний 5 сард 131652:27:00 даалгаварт цаг гүйцэтгэхээс 11723:36:30 цаг буюу 87,7% гүйцэтгэсэн. Ашиглалтын саатал 2068:10:30 цаг, техникийн саатал 6329:05:30 цаг, эх авалт 589:19:00 цаг, оройн буулт 488:53:45 цаг, цэнэглэлт 3277:20:30 цаг, зогсоолд зогсоогүй зөрчил 248:34:00 цаг, “Улаанбаатар Смарт Карт” ХХК-аас 3801:58:00 цаг авахаас 3038:27:00 цаг | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | авч, 763:31:00 цагийг аваагүй. Тээвэр, хөдөлгөөн зохицуулагч нарын авч байгаа цаг дээр хяналт тааруу.<br>❖ “Улаанбаатар Смарт Карт” ХХК-тай ажлын цагийн гүйцэтгэл тооцсон байдал- Эхний 5 сард 131652:27:00 даалгаварт цаг гүйцэтгэхээс 11723:36:30 цаг буюу 87,7% гүйцэтгэсэн. Ашиглалтын саатал 2068:10:30 цаг, техникийн саатал 6329:05:30 цаг, эх авалт 589:19:00 цаг, оройн буулт 488:53:45 цаг, цэнэглэлт 3277:20:30 цаг, зогсоолд зогсоогүй зөрчил 248:34:00 цаг, “Улаанбаатар смарт карт” ХХК-аас 3801:58:00 цаг авахаас 3038:27:00 цаг авч, 763:31:00 цагийг аваагүй. Тээвэр, хөдөлгөөн зохицуулагч нарын авч байгаа цаг дээр хяналт тааруу.<br>Газрын даргаас болон шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, үр дүн- Тайлант хугацаанд Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтэст удирдах ажилтны шуурхай зөвөлгөөнөөс67 үүрэг даалгавар өгөгдсөнөөс 11 үүрэг даалгаврыг огт биелүүлээгүй. Тоон үзүүлэлт, хийсэн ажлын үр дүн, биелэгдээгүй шалтгаан зэргийн тайлбар байхгүй.Үүрэг даалгаврын биелэлтийг тайлбар маягаар хааж, үнэлгээг 100%-аар дүгнэдэг зэрэг зөрчилтэй. Хийсэн ажлын тайланг газрын даргад танилцуулж, Тээвэрлэлт, үйлчилгээний хэлтэст зөрчил арилгах зөвлөмж хүргүүлж, зөрчлийг арилгасан талаар тайлан ирүүлсэн боловч шаардлага хангахгүй. | |
| 14 | ***Арга хэмжээ 3.9***<br>Нийтийн тээврийн шугамын үйлчилгээний цаг, рейсийн алдагдалгүй, ТБОХ-д бүртгэлээр хяналт, шалгалтыг зохион байгуулах | Өөрийн хөрөнгө | Зөрчил буурсан байна. | 100% | 100% | 100% | 2021 онд ТБОХ-ийн зөрчил буюу зогсоолд зогсоогүй зөрчил 390:59 цаг, 2022 онд 175:58:00 цагийн зөрчил гаргаж, өмнөх оноос 215:01:00 цаг буюу 44,9%-аар бууруулсан.<br>Эх авалт даалгаварт цаг 20539 байхаас 19505 гүйцэтгэж, 2014:41 цаг тасарч 94,9%-ийн гүйцэтгэлтэй, оройн буулт 12119 байхаас 11466 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | гүйцэтгэж, 1248:05 цаг тасарч 94,6%-ийн гүйцэтгэлтэй. Эх авалт, оройн буулт тасарч байгаа нь тээврийн хэрэгслийн насжилт дуусч техникийн эвдрэл, сэлбэг материалын хомсдол зэргээс шалтгаалсан.<br>Жолооч хоцрох, ажил таслах зэргээс шалтгаалж өглөөний эх авалт тасалсан жолооч нараас эх авалтын торгуулийг 150000 төгрөгөөр тооцон 32 жолооч тус бүрд эх авалтын торгууль ногдуулсан. 2021 онтой харьцуулахад 215:01:00 цаг буюу 44,9%-иар бууруулсан. | |
| 15 | ***Арга хэмжээ 3.10***<br>Техник, технологийн хэлтэст 2021 онд өгсөн зөвлөмжийн дагуу хийсэн ажлын үр дүн, 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд газрын даргын баталсан удирдамжийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Өөрийн хөрөнгө | Шалгалтын үр дүнг газрын даргад танилцуулна. | 100% | 100% | 100% | Зөвлөмжийн дагуу хийсэн ажлын тайлан байхгүй. 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээний ажлыг хийж үйл ажиллагааны явцыг 63,7%-тай ажлыг “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж дүгнэсэн. Батлагдсан хуваарийн дагуу ТҮ-1.2-ыг тогтмол хийж хийгээгүй. Техникийн бэлэн байдлын коэффциентын өсөлт, бууралтыг тайлангаас харах боломжгүй. | 100% |
| 16 | ***Арга хэмжээ 3.11***<br>Засварын инженерүүдийн ажил үүргийн гүйцэтгэл, засварын хуваарь график мөрдөлтөд хяналт, шалгалт хийх | Өөрийн хөрөнгө | Биелэлт хувь | 100% | 100% | 100% | 2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ-Техник, технологийн хэлтсийн засварын инженерийн хагас жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 бүлэгтэй 24 ажил хийхээр боловсруулж, хэлтсийн дарга Р.Баясгалангаар 2022 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр батлуулсан. Ажлын гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 50%-тай буюу ажлыг “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж дүгнэсэн. Техник, технологийн хэлтсийн ахлах инженерт зөрчил арилгах зөвлөмж хүргүүлсэн. | 100% |
| 17 | ***Арга хэмжээ 3.12***<br>Тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагаа, стандартын үзлэг шалггалтыг зохион байгуулах | Өөрийн хөрөнгө | Биелэлт хувь | 100% | 100% | 100% | Техникийн бүрэн бүтэн байдлын үзлэгийг тайлант хугацаанд 6 удаа зохион байгуулж, 677 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгах, ажлыг чанаржуулах талаар Техник, технологийн хэлтэст зөвлөмж, зөрчлийн хуудсыг хүргүүлж, Техник, технологийн хэлтсээс хурдны | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэмжигчээс бусад зөрчлийг арилгаж, 634 зөрчил буюу 93,6%-иар бууруулсан үр дүнтэй. | |
| 18 | ***Арга хэмжээ 3.13*** Онлайн камераар хяналт, шалгалтыг зохион байгуулах | Өөрийн хөрөнгө | Биелэлт хувь | 100% | 100% | 100% | Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж буй автобусны жолооч нар 6 төрлийн 555 зөрчил гаргаснаас гарын оролцоотой утсаар ярьсан 95, тамхи татсан 34, камер халхалсан 110, ажлын хувцасгүй 102, бэлэн мөнгө авсан 82, суудлын бүс зүүгээгүй 102 тус тус гаргасан. Зөрчлийн гаргасан байдлыг хэсгээр нь гаргаж үзэхэд 1 дүгээр 256, 2 дугаар хэсэг 225, 3 дугаар хэсэг 74 гаргасан. 2021 онд 5 төрлийн 125 зөрчил бүртгэгдэж байсан 2022 онд 555 зөрчил бүртгэгдэж зөрчлийн тоо 430 нэмэгдсэн. Жолооч нарын 70% шинэчлэгдсэн, сахилга бат тааруу байна гэж дүгнэж байна. | 100% |
| 19 | ***Арга хэмжээ 3.14*** Камерын системийн доголдол, гэмтэл илэрсэн үед "Улаанбаатар смарт карт" ХХК-д мэдэгдэж засварлуулах | Өөрийн хөрөнгө | Биелэлт хувь | 100% | 100% | 100% | 3.14.1.Тайлант хугацаанд 7 удаа давхардсан тоогоор 167 автобусанд онлайн камерын засвар үйлчилгээний ажлыг "Улаанбаатар Смарт Карт" ХХК-ны засварын инженерүүдтэй хамтран хийсэн. Парк шинэчлэлтийн хүрээнд орж ирсэн 11 автобусанд смартын тоног төхөөрөмжийг суурилуулах ажлыг хийж шугамын үйлчилгээнд гаргасан. | 100% |
| | | | | | | | 3.14.2. Парк шинэчлэлтийн хүрээнд орж ирсэн 11 автобусанд смартын тоног төхөөрөмжийг суурилуулах ажлыг хийж шугамын үйлчилгээнд гаргасан. | |
| Хэсгийн дундаж үнэлгээ 98,5% | | | | | | | | |
| Стратеги төлөвлөгөөний зорилго **Дөрөв. Байгууллагын ил тод байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх** | | | | | | | | |
| 19 | ***Арга хэмжээ 4.1*** Шилэн дансны хөтлөлт, хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Өөрийн хөрөнгө | Биелэлт хувь | 100% | 100% | 100% | Хуулийн хэрэгжилтийг ханган үйлдвэрийн газрын төсөв, гүйцэтгэл, бүтэц орон тоо, 5 сая төгрөгөөс дээш худалдан авах ажил үйлчилгээ, аудитын тайлан, дүгнэлт, тендерийн ерөнхий мэдээллийг сар бүрийн 05-ны өдрийн дотор шилэн дансны shilendans.gov.mn сайтад 117 мэдээлэл оруулахаас 112 мэдээллийг хугацаанд нь оруулж 5 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн. Худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээлэл -2,5 саяас дээш гүйлгээний дүн мэдээ - 3 тус тус хоцроосон хангалттай гэж дүгнэсэн. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 20 | ***Арга хэмжээ 4.2*** Байгууллагын шударга байдал, мэдээлэл технологийн бодлогын хэрэгжилт, хэвлэл мэдээлэл, олон нийтийн ажилд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | Өөрийн хөрөнгө | Биелэлт хувь | 100% | 100% | 100% | ❖ Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах зорилтын хүрээнд 10 арга хэмжээг зохион байгуулснаас 9 ажил 100%, 1 ажил 87% хэсгийн дундаж 98,7%-тай. Хүний нөөцийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах зорилтын хүрээнд 6 арга хэмжээ зохион байгуулснаас 5 ажил 100%, 1 ажил 80% хэсгийн дундаж хувь 96,6%-тай.Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын зорилтын хүрээнд 13 арга хэмжээ зохион байгуулснаас 7 ажил 100%, 1 ажил 98%, 5 ажил 95% хэсгийн дундаж хувь 97,9%-тай**.** Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын зорилтын хүрээнд 2 арга хэмжээ зохион байгуулж 100%-тай**.** Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хувьд 5 ажил төлөвлөн 100%-ийн хэрэгжилттэй. Холбогдох ажилтанд зөвлөгөө өгч ажилласан. | 100% |
| Хэсгийн дундаж үнэлгээ -100% | | | | | | | | |
| Стратеги төлөвлөгөөний зорилго **Тав. Бусад ажлын хүрээнд** | | | | | | | | |
| 21 | ***Арга хэмжээ 5.1*** Дотоод хяналт шалгалтын ажилтнууд болон хяналтын операторуудыг ур чадварыг дээшлүүлэх сургалтанд хамруулах | 2,5 сая | Биелэлт хувь | 0% | 100% | 100% | Тайлант хугацаанд хэлтсийн ажилчид нийт 12 удаагийн сургалтын арга хэмжээнд оролцохоос 11 сургалтанд хамрагдсан. 1 мэргэшүүлэх сургалт хэмнэлтийн тухай хууль гарсантай холбогдуулан цуцлагдсан. 11 сургалтанд давхардсан тоогоор 66 ажилтан хамрагдахаас 55 ажилтан буюу 83,3% нь хамрагдсан. | 80% |
| 22 | ***Арга хэмжээ 5.2*** Камер шүүлгэх талаар холбогдох байгууллага, иргэдээс ирсэн албан бичиг, өргөдлийг урирдлагын цохолтоор шийдвэрлэх | Өөрийн хөрөнгө | Биелэлт хувь | 100% | 100% | 100% | Тайлан хугацаанд газрын дарга болон хэлтсийн даргын зөвшөөрсөн цохолтын дагуу 40 өргөдөл, 5 албан бичгийн дагуу онлайн камерын бичлэгийг шүүж хуулийн хугацаанд барагдуулан шийдвэрлэсэн. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 23 | ***Арга хэмжээ 5.3*** Нийтийн тээврийн үйлчилгээний газартай шугамын хяналтын талаар хамтарч ажиллах | Өөрийн хөрөнгө | Биелэлт хувь | 100% | 100% | 100% | ❖ Нийтийн тээврийн газрын тээврийн хяналтын хэлтэст сар бүрийн ажлын 5 хоногт шугамын хяналтын мэдээг хүргүүлж ажилласан.<br>❖ Газрын даргын 01 дүгээр удирдамжийн дагуу үйлдвэрийн газрын үйлчилж 13 чиглэлд 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд ажлын зураг авалтыг зохион байгуулж ажилласан. Шалгалтын хугацаанд орсон орлого (баярлалаа -29654, ахмад -11470, хөнгөлттэй зорчигч -10078, оюутан-7989, хүүхэд -9575, дамжин суулт -6891,тусгай карт-1332). Пос машин -1 сард 14911900 төгрөг, 2-сард 12312700 төгрөг, 3-сард 18334800төгрөг, нийт 45559400 төгрөгийн орлого хийж, нийт орлогын 1%-ийг байгууллагын дансанд оруулсан.<br>2022 оны 06 сарын 03-ны өдрөөс эхлэн 2 давхар цахилгаан автобусны 2 дугаар давхарт өдөрт 10 шалгагчийг хуваарийн дагуу, зөрчилгүй ажиллуулсан. | 100% |
| 24 | ***Арга хэмжээ 5.4*** “Улаанбаатар смарт карт” тай онлайн камерын засвар үйлчилгээ ашиглалтын тал дээр хамтарч ажиллах | Өөрийн хөрөнгө | Биелэлт хувь | 100% | 100% | 100% | Тайлант хугацаанд 6 (зургаа) удаа автобусанд байрших онлайн камерын засвар үйлчилгээний ажлыг “Улаанбаатар Смарт Карт” ХХК-ны засварын инженерүүдтэй хамтран хийсэн. Парк шинэчлэлтээр орж ирсэн 11 автобусанд смартын тоног төхөөрөмжийг суурилуулах ажлыг хийж шугамын үйлчилгээнд гаргасан. | 100% |
| | ***Арга хэмжээ 5.5.*** Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас “Шарилжгүй Улаанбаатар” аян зохион байгуулсан ажлын хүрээнд | Өөрийн хөрөнгө | Биелэлт хувь | | | 100% | Байгууллагын хашаа болон ойр орчмын 50 метр газрыг цэвэрлэхэд 2 удаа давхардсан тоогоор 49 ажилтан оролцсон.<br>Цэвэрлэгээ хийхэд хэлтсийн ажилчид 100% оролцсон. | 100% |
| | ***Арга хэмжээ 5.6.*** | Өөрийн | Биелэлт | 100% | | 100% | СХД-ийн 24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах “Бумбатын рашаан” орчим байгууллагаас зохион байгуулсан мод тарих үйл | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | “Тэр бум мод” аяны хүрээнд | хөрөнгө | хувь | | | | ажиллагаанд хэлтсийн 26 ажилтан идэвхтэй оролцсон. | |
| | ***Арга хэмжээ* 5.7.** Биеийн тамир, спортын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд: | Өөрийн хөрөнгө | Биелэлт хувь | 100% | 100% | 100% | Нийтийн тээврийн салбарын аварга шалгаруулах тэмцээнд 6 төрөлт тэмцээнд байгууллагын багт тус хэлтсийн дарга Л.Отгонбаатар, хяналтын ажилтан М.Доржханд, Б.Шинэбаатар, хяналтын оператор Б.Оюунцэцэг, Д.Баянмөнх, шалгагч Ж.Дэлгэрмаа нар оролцсон. Б.Оюунцэцэг теннисийн төрөлд хүрэл медаль хүртсэн. Байгууллагын аварга шалгаруулах 5 төрөлт спортын тэмцээнд идэвхтэй оролцож, гар бөмбөг, сагсан бөмбөг эмэгтэй тамирчид Алтан медаль, теннисийн төрөлд Б.Оюунцэцэг Алтан медаль, Ж.Дэлгэрмаа Мөнгөн медаль, Гар бөмбөгийн “Шилдэг тамирчин”-аар Ж.Дэлгэрмаа шалгарсан. Системийн тэмцээнээс 1 хүрэл медаль, байгууллагын спортын наадамд 4 алтан медаль, 1 мөнгөн медаль хүртсэн амжилттай. | 100% |
| | ***Арга хэмжээ* 5.8.** Ажилчдыг идэвхжүүлэх ажлын хүрээнд: | Өөрийн хөрөнгө | Биелэлт хувь | | | 100% | Хэлтсийн ажилчдын санаачлагаар захиргааны эмэгтэй ажилчдын дунд “Цэцэгт мэндчилгээ”арга хэмжээг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулсан. | 100% |
| | ***Арга хэмжээ* 5.9.** Ажилчдыг идэвхжүүлэх ажлын хүрээнд: | Өөрийн хөрөнгө | Биелэлт хувь | | | 100% | Хэлтсийн ажилчдын санаачлагаар “Хишиг өдөр”-ийг байгууллагын захиргаа, инженер техникийн ажилчдын дунд зохион байгуулсан. | 100% |
| | ***Арга хэмжээ* 5.9** Шинээр санаачлан хийсэн ажил | Өөрийн хөрөнгө | Биелэлт хувь | | 100% | 100% | Парк шинэчлэлээр орж ирсэн 47 цахилгаан автобуснуудын камерыг онлайн болгож, автобусны зорчих маршрутыг хянах GPS төхөөрөмжийг суурилуулан нийтийн тээврийн салбарт нэвтрүүлж, үйл ажиллагаандаа амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Хяналтын операторуудын ажлын ачааллыг хөнгөвчилсөн, ажилчид, иргэд, аж ахуйн нэгж байгууллагын гаргасан өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэх нөхцлийг бүрдүүлсэн. | 100% |
| Хэсгийн дундаж үнэлгээ 97,7% | | | | | | | | |

| Ерөнхий дундаж үнэлгээ 99,2% |
| --- |

***Дүгнэлт:*** Тайлант хугацаанд 5 зорилтод 31 арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөж, зохион байгуулж хэрэгжилтийг хангаж ажилласан. Хэрэгжүүлсэн арга хэмжээ, ажлын хувьд 28 арга хэмжээ 100% гүйцэтгэлтэй. 99,5%-ийн гүйцэтгэлтэй- 1, 80%-ийн гүйцэтгэлтэй 2 арга хэмжээ. Хэлтсийн ажлын ерөнхий дундаж үнэлгээ 99,2%-тай бүрэн хангалттай биелсэн.

Зорилт-1. “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн”-100%
Зорилт-2. "Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үр дүн" -99,8%
Зорилт-3. "Байгууллагын үйл ажиллагааны үр дүн" -98,5%
Зорилт-4. “Байгууллагын ил тод байдал, түүний хэрэгжилт үр дүн”-100%
Зорилт-5.Бусад ажлын хүрээнд:- 97,7%
Ерөнхий дундаж үнэлгээ 99,2%

*Төлөвлөгөөний биелэлтийг үнэлсэн:* “ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ”ОНӨААТҮГ-ЫН ДАРГА О.ГАНБААТАР

*Тайлан хянасан:* ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Л.ОТГОНБААТАР

*Тайланг нэгтгэсэн:* ДХШХ-ИЙН АХЛАХ АЖИЛТАН Л.ТУЛГА